

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар: 16

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.10, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн 3.1.2, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан Үндэсний давхар даатгал ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК нь Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолд заасны дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах компанийн жагсаалтад багтсантай холбогдуулан “Санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалахтай холбоотой зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Компанийн хувьцааг анхдагч зах зээл дээр арилжаалах бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолыг 2022 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

3.ЭНХБОЛД



“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 16
дугаар тогтоолын ХАВСРАЛТ
зөвлөл

ХАВСРАЛТЫН
ЗӨВЛӨЛ

**САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР ҮНЭТ ЦААС
ГАРГАХ, АРИЛЖААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Үндэсний давхар даатгал” ХК /цаашид “Компани” гэх/-ийн хувьцааг Компанийн тухай хууль, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийн дагуу Монгол Улсын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгоход ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, шуурхай байх, хөрөнгийн биржийн шаардлагад нийцүүлэх зарчмыг баримтална.

1.3. Компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалахтай холбоотой зөвлөх үйлчилгээнээс бусад үйл ажиллагаанд хамааралтай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

Хоёр. Нэр томъёо

2.1. Энэхүү журамд орсон дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. “Зөвлөх үйлчилгээ” гэж “Үндэсний давхар даатгал” ХК-ийн хувьцааг дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай ажлууд бөгөөд энэ журмын хавсралтад заасан зөвлөх үйлчилгээг;

2.1.2. “Захиалагч” гэж компанийн гүйцэтгэх захирлыг;

2.1.3. “Ажлын хэсэг” гэж сонгон шалгаруулалтыг энэ журмын 3.1-д заасны дагуу сонгон шалгаруулалтын бичиг баримтыг боловсруулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий захиалагчийн шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийг;

2.1.4. “Оролцогч” гэж энэ журмын 4.1.1-т заасны дагуу захиалагчийн баталсан нөхцөл, шаардлагыг хангах туршлага, үр чадвар, чадавх, нэр хүнд бүхий хуулийн этгээдүүд, мөн саналын урилга ирүүлэхийг хүссэн бусад хуулийн этгээдийг;

2.1.5. “Сонгон шалгаруулалтын баримт бичиг” гэж зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулалттай холбоотой энэ журмаар зохицуулаагүй харилцааг нарийвчлан зохицуулсан компанийн Гүйцэтгэх удирдлагаас баталсан баримт бичгийг;

Гурав. Ажлын хэсэг, түүний бүрэлдэхүүн

3.1. Захиалагч нь энэхүү журмын хавсралтад заасан шаардлагатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах сондгой тооны бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг компанийн Гүйцэтгэх удирдлагын тушаалаар байгуулна.

3.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь ахлагч, гишүүд, хараат бус гишүүн, нарийн бичгийн дарга гэсэн нийт 5 гишүүнтэй байна.

3.3. Хараат бус гишүүнийг компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах ажлыг гүйцэтгэж байсан туршлагатай этгээдүүдээс нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгоно.

3.4. Ажлын хэсгийн ахлагчаар компанийн Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газрын дарга, гишүүдэд Комплаенс, нөхөн төлбөрийн газрын дарга, үнэт цаасны асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар худалдан авалт хариуцсан ажилтныг тус тус томилно. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаанд компанийн Захиргаа, удирдлагын газраас дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Оролцогчдын жагсаалт, тавигдах шаардлагыг тогтоох

4.1. Энэхүү журмын 3.1-д заасан Ажлын хэсэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. Зөвлөх үйлчилгээ тус бүрээр оролцогчдод тавигдах шаардлага, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, туршлага, мэргэжлийн түвшин, дотоодын болон олон улсын түвшний мэргэжлийн нэр хүнд, бусад ур чадвар, техникийн чадавх болон санхүүгийн чадавхын үзүүлэлтийг үнэлэхэд ашиглах нөхцөл, шаардлагыг тогтоох саналыг боловсруулж, захиалагчаар батлуулах;

4.1.2. Шаардагдаж байгаа зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгаврыг бэлтгэх;

4.1.3. Жагсаалт үүсгэх зорилгоор болон жагсаалтад орсон оролцогчидтой харилцах, тэдгээрийн асуулт, тодруулгад хариу өгөх, тэдгээрийн чадавх, үйл ажиллагааны талаарх мэдээллийг цуглуулах, бэлтгэх;

4.1.4. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх боломжтой оролцогчдын жагсаалтыг гаргах

4.1.5. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад баримтлах журам, үйлчилгээний цар хүрээ, үйлчилгээ гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний ерөнхий нөхцөлийг тодорхойлох;

4.1.6. Оролцогч этгээдэд хүргүүлэх саналын урилга, оролцогчоос ирүүлэх санал, баримт бичгийн агуулга, бүрдлийн шалгуурыг тогтоох;

4.1.7. Сонгон шалгаруулалттай холбоотой оролцогчдоос шаардах баталгаа, түүнтэй холбоотой харилцааны зохицуулалтыг тогтоох;

4.1.8. Оролцогчдоос ирүүлсэн санал, нотлох баримт бичгийг үнэлэх, дүгнэлт гаргах.

4.2. Ажлын хэсэг зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчид тавигдах шаардлагыг тогтоохдоо тухайн зөвлөх үйлчилгээний онцлогийг харгалзан үнэт цаасыг арилжаалах ажиллагааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор нэгээс дээш оролцогчийг төсөвт багтаан шалгаруулахаар тогтоож болно.

Тав. Урилга илгээх, оролцогчдын саналыг хүлээн авах

5.1. Компани нь сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангасан оролцогчдын жагсаалтад нэр нь орсон таваас доошгүй этгээдэд саналын урилгыг хүргүүлнэ.

5.2 Зөвлөхийн санал хүргүүлэхээр сонирхсон жагсаалтаас гадуурх хуулийн этгээд болон жагсаалтад орсон оролцогч бүх этгээдийг сонгон шалгаруулах ажиллагаанд оролцох тэгш боломжоор хангана.

5.3. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын баримт бичгийг саналын урилгад заасан хугацаа, хаягаар ирүүлэх бөгөөд оролцогч нь энэ хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах саналаа ирүүлж болно.

Зургаа. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэлт гаргах

6.1. Ажлын хэсэг нь товлосон газарт санал, баримт бичгийг хүлээн авах эцсийн хугацаа дуусахад зөвлөхийн санал авахыг үйл ажиллагааг зогсоох бөгөөд эцсийн хугацаанаас хойш ирсэн материалыг хүлээж авахгүй.

6.2 Зөвлөхийн саналын эцсийн хугацаа дуусахад энэхүү ажиллагаанд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээдүүдийг байлцуулан оролцогчдын нэр,

тэдгээрийн ирүүлсэн баримт бичгийн жагсаалтын талаарх мэдээллийг тусгасан тэмдэглэл үйлдэж холбогдох талуудын төлөөллөөр гарын үсэг зуруулна.

6.3. Ажлын хэсэг зөвлөх үйлчилгээний оролцогчдоос ирүүлсэн санал, баримт бичгийг нэг бүрчлэн үнэлж, санал болгож байгаа зөвлөх үйлчилгээний үйл ажиллагааны арга зүй, ажлын хуваарь, боловсон хүчний туршлага, чадварыг харьцуулсан шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

6.4. Ажлын хэсгийн ахлагч нь хуралдааныг товлох, удирдан зохион байгуулах, нарийн бичгийн дарга нь хуралдааныг зарлан мэдээлэх, хуралдааны бэлтгэл ажлыг хангах, холбогдох мэдээллээр дарга, гишүүдийг хангах, хурлын тэмдэглэлийг хөтлөх, шийдвэрийг баталгаажуулах үүрэгтэй ба хуралд ирсэн гишүүдийн ирцийг тухай бүр бүртгэж, хуралд ирээгүй гишүүдийн шалтгааныг тэмдэглэж баримтжуулна.

6.5. Ажлын хэсгийн нийт гишүүдийн 80-аас дээш хувийн ирцтэйгээр хуралдааны шийдвэр хүчин төгөлдөр тооцогдоно.

6.6. Ажлын хэсгийн гишүүд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэлтэй танилцах, үнэн зөв мэдүүлэг гаргах, гарын үсгээр баталгаажуулах, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд татгалзана.

6.7. Ажлын хэсгээс гаргасан шийдвэр нь дүгнэлт, хурлын тэмдэглэлээс бүрдэх бөгөөд нийт гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл болон холбогдох мэдээллийг агуулсан байна. Дүгнэлт, хурлын тэмдэглэлд гишүүн тус бурийн үнэлгээний хуудсыг хавсаргана.

6.8. Ажлын хэсгийн дүгнэлтэд бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн энэ тухайгаа тэмдэглэж гарын үсэг зурна.

6.9. Сонгон шалгаруулалтад зөвхөн нэг оролцогч санал ирүүлсэн бөгөөд тухайн ирүүлсэн санал, баримт бичиг нь тогтоосон нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд сонгон шалгаруулалт хүчинтэй болно.

Долоо. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох, гэрээ байгуулах

7.1. Ажлын хэсгийн ахлагч нь зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж дуумагц ажлын хэсгийн шийдвэрийг захиалагчид танилцуулна.

7.2. Захиалагч нь ажлын хэсгийн дүгнэлтийг хянаж үзээд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгож, гэрээ байгуулах талаар хэлэлцээ хийнэ.

7.3. Шалгарсан оролцогчтой байгуулах гэрээний нөхцөлийн талаар Ажлын хэсэг хэлэлцээр хийж, гэрээний төслийг эцэслэн тохиролцно.

7.4. Захиалагч энэ журмын 7.3-т заасныг үндэслэн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулна.

7.5. Энэхүү журмаар зохицуулаагүй гэрээ байгуулахтай холбоотой бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд зааснаар зохицуулна.

Найм. Бусад

8.1. Оролцогчдын зүгээс ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой үндэслэл бүхий гомдлыг тухайн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох ажлын хэсгийн дүгнэлт гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид гаргаж болно.

8.2. Захиалагч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор хянаж шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрт гомдлыг хүлээж аваагүй бол түүний үндэслэл, гомдлыг хүлээн зөвшөөрсөн бол түүнийг барагдуулах арга хэмжээг тусгасан байна.

8.3. Ажлын хэсгийн үйл ажиллагааны үр дүнгээр бий болсон бүх баримт материалыг Архивын тухай хууль тогтоомжийн дагуу компанийн архивд хадгалах ажлыг холбогдох чиг Үүргийн газар, нэгж гүйцэтгэнэ.

--ooOoo--

“Санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах,
арилжаалахтай холбоотой зөвлөх үйлчилгээний
гүйцэтгэгч сонгох журам”-ын Хавсралт

МОНГОЛЫН
ХАРДЫН НАСААР
ТӨЛӨӨЛГӨН ҮЗҮҮЛЭХ
ЗӨВЛӨЛ

УДААНБААТАРЫН
ТӨЛӨӨЛГӨН ҮЗҮҮЛЭХ

ШААРДЛАГАТАЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Нэг. Хөрөнгийн биржид бүртгүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээ:

1. “Андеррайтерийн зөвлөх үйлчилгээ” гэж компанийн нийтэд санал болгож буй хувьцааны танилцуулгыг бэлтгэх, хувьцааны үнийг тодорхойлох, хөрөнгийн зах зээл дээр гаргаж нээлттэй арилжаалах ажлыг зохион байгуулах үйлчилгээг үзүүлнэ.
2. “Хуулийн зөвлөх үйлчилгээ” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн журамд заасан асуудлаар буюу үнэт цаас гаргагч, үнэт цаасны танилцуулгын талаар магадлан шинжилгээ (due diligence) хийх, хууль зүйн дүгнэлт гаргах үйлчилгээг үзүүлнэ.
3. “Аудитын зөвлөх үйлчилгээ” гэж компанийн санхүүгийн тайланд олон улсын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын стандартын дагуу хараат бусаар аудитын дүгнэлт гаргах үйлчилгээг ойлгоно.
4. “Хөрөнгийн үнэлгээний зөвлөх үйлчилгээ” гэж компанийн хөрөнгийн болон зах зээлийн үнэлгээг олон улсын стандартын дагуу хараат бус тогтоож санал болгох үйлчилгээг үзүүлнэ.